

Богино палиндром

n ширхэг англи цагаан толгойн жижиг үсгүүдээс тогтох S тэмдэгт мөр өгөгдөв.

$S[i]$ нь S тэмдэгт мөрийн i дугаар тэмдэгтийг илэрхийлнэ. ($0 \leq i < n$)

S тэмдэгт мөрийн дугаарыг илэрхийлэх дараах нөхцөлүүдийг хангах (a, b, c, d) гэсэн палиндром дөрвөлийн дарааллыг авч үзье.

- $S[a] = S[d]$ буюу a, d дугаарт байгаа тэмдэгтүүд ижил байна.
- $S[b] = S[c]$ буюу b, c дугаарт байгаа тэмдэгтүүд ижил байна.
- $0 \leq a < b < c < d < n$ буюу S тэмдэгт мөрийн индексийг илэрхийлэх a, b, c, d индексүүд өсөх дараалалтай байна.

Тэгвэл дээрх нөхцөлүүдийг хангах (a, b, c, d) дөрвөлүүдийн тоог ол.

Хариу нь маш том тоо гарч болох тул 10^9+7 тоонд хувааж үлдэгдлийг хэвлэнэ үү?

Оролтын хэлбэр

S тэмдэгт мөр өгөгдөнө.

Хязгаарлалт

$1 \leq |S| \leq 10^6$

S тэмдэгт мөрийн бүх үсгүүд англи цагаан толгойн жижиг үсгүүдээс тогтох нь батлагдсан.

Гаралтын хэлбэр

Бодлогын нөхцөлийг хангах дөрвөлүүдийн тоог хэвлэнэ. Хариу маш том тоо гарч болох тул

10^9+7 тоонд хуваасан үлдэгдлийг /модульдаж/ хэвлэнэ.

Жишээ

Оролт 1

kkkkkkz

Гаралт 1

15

Тайлбар 1

Бодлогын нөхцөлийг ядаж хамгийн багадаа 2 ижил байх тэмдэгт хангах тул z үсэг дөрвөлийн нэг болж чадахгүй учир тэдгээр дөрвөл нь k –уудаас тогтох нь илэрхий байна.

Тэгвэл 6 ширхэг k -аас 4-ийг сонгох боломжийн тоог олох хэрэгтэй болж байгаа бөгөөд энэ нь 15 байна.

Оролт 2

ghhggh

Гаралт 2

4

Тайлбар 2

Тэдгээр дөрвөлүүд нь:

- (0, 1, 2, 3)
- (0, 1, 2, 4)
- (1, 3, 4, 5)
- (2, 3, 4, 5)

Тиймээс хариу нь $4 \pmod{(10^9+7)} = 4$

Оролт 3

akakak

Гаралт 3

2

Тайлбар 3

Тэдгээр дөрвөлүүд нь (1, 2, 4, 5) ба (0, 1, 3, 4)

Орчуулсан : Хөвсгөл аймгийн Ирээдүй сургуулийн багш Д.Батмөнх

[Submit solution!](#)